

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН
БОДЛОГО, ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН КОД: ГНАГ-2024/19-ШТА-ГА

ТӨРИЙН АЛБАНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ХОМСДОЛ ҮҮССЭНЭЭС ТӨРИЙН АЛБАН
ХААГЧДААР АЖИЛ ХАВСРАН ГҮЙЦЭТГҮҮЛЭХ, ЗЭРЭГЦЭЭ ХӨДӨЛМӨР
ЭРХЛҮҮЛЭХ, ӨНДӨР НАСНЫ ТЭТГЭВЭР ТОГТООЛГОСОН ИРГЭДИЙГ
“ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ”-ГЭЭР АЖИЛЛУУЛАХ ЯВДАЛ НИЙТЛЭГ БАЙДЛААР
ОРШИЖ БАЙНА.

Сүхбаатар сум 2024 он



Дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Болор

Утас: 70362442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Аудитор О.Анхбаяр

Утас: 70362442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn

Аудитор Б.Наранцэцэг

Утас: 70362442

Цахим хаяг: narantsetsegba@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу: Цахим хуудас: www.open.audit.mn

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Хүснэгт, дүрслэл, хавсралтын товъёг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Ерөнхий мэдээлэл

Бүлэг 1. Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн эсэх?

1.1. Аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулж, мөрдөөгүй байна.

1.2. Төрийн байгууллагын үйлчилгээг чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх хүний нөөцийн тогтолцоо бүрдсэн хэдий ч төрийн албаны хүний нөөцийн хомсдол үүссэн байна.

1.3. Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудын сул ажлын байрыг холбогдох хууль, журмын хүрээнд нөхөн томилоогүй бөгөөд зарим байгууллагууд сул орон тооны сонгон шалгаруулалтыг нийтэд зарлаагүй байна.

Бүлэг 2. Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх?

2.1. Иргэнд үйлчилдэг мэргэшсэн, чадварлаг, ил тод төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор төрийн албан хаагчдыг олон тооны сургалтад хамруулж байгаа хэдий ч үр дүнг үнэлж, тооцохгүй байна.

2.2. 2020-2023 онуудад Сэлэнгэ аймаг нь 73 төрийн үйлчилгээг E-Mongolia системд холбож, операторын хэлбэрээр 64646 иргэнд үйлчилсэн байна.

2.3. Иргэдийн 52.5 хувь нь төрийн байгууллагын үйлчилгээг ил тод, нээлттэй байна гэж үзсэн байна.

ДҮГНЭЛТ

ЗӨВЛӨМЖ

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БИНХ	Багийн иргэдийн Нийтийн хурал
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БСШУ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗЗНДНТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТАТХ	Төрийн албаны тухай хууль
ТАЦНС	Төрийн албаны цалингийн нэгдсэн систем
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УИХ	Улсын их хурал
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ХНУМТ	Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХШУДАХ	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ЦХИХХ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны
ЭМГ	Эрүүл мэндийн газар

Хүснэгтийн товъёг:

Хүснэгт 1. Төрийн захиргааны байгууллага өөрт учирсан хохирлыг буцаан төлүүлсэн эсэх

Хүснэгт 2. Удирдлагын академиас зохион байгуулсан мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байдал

Хүснэгт 3. Мэргэжлийн болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байдал

Хүснэгт 4. Төрийн албан хаагчдыг сэлгэн болон шилжүүлэн ажилласан байдал

Дүрслэлийн товъёг:

Дүрслэл 1. Сэлэнгэ аймгийн төрийн албан хаагчдын 2023 оны байдлаарх хүйсийн байдал, албан тушаалын ангиллаар /хүний тоогоор/

Дүрслэл 2. ХНУМТ системд албан хаагчдын мэдээллийг оруулсан байдал /хувиар/

Дүрслэл 3. “Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх” зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Дүрслэл 4. Сумдын ЗДТГ-ын төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудын хүйсийн байдал /хүний тоогоор/

Дүрслэл 5. Төрийн байгууллагад хэмжээнд ажилласан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа /тоогоор/

Дүрслэл 6. Сэлэнгэ аймгийн цахим ил тод байдлын түвшин

Хавсралтын товъёг:

Хавсралт 1. Аймаг, сумдын ЗДТГ-ын 2012-2023 оны батлагдсан орон тооны судалгаа

Хавсралт 2. Төр, төсвийн байгууллагуудын бүтэц, орон тоо болон төсвийн шууд захирагчийн томилгоо /аймгийн Засаг даргын баталсан/

Хавсралт 3. Сул ажлын байрыг хавсран гүйцэтгүүлсэн судалгаа

Хавсралт 4. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон боловч ажиллаж буй иргэдийн судалгаа

Хавсралт 5. Зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй нягтлан бодогчдын судалгаа

Хавсралт 6. Сонгон шалгаруулалтгүйгээр томилсон ЭМТ-ийн даргын судалгаа

Хавсралт 7. Багийн ИНХ-ын шийдвэргүйгээр томилогдсон багийн дарга нарын судалгаа

Хавсралт 8. Сонгон шалгаруулалтгүй томилогдсон албан хаагчдыг чөлөөлсөн тухай судалгаа

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт:

“Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, хууль эрх зүйг хэрэгжүүлэх тогтолцоо бүрдсэн эсэх;
- Төрийн байгууллагуудын хүний нөөцийн тогтолцоо нь сайн засаглалыг бий болгож байгаа эсэх;

Аудитын хамарсан хүрээ:

Аудитаар төрийн зорилт, чиг үүргийг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлдэг төрийн бодлого боловсруулах, төрөөс зайлшгүй үзүүлэх шаардлагатай бусад үйлчилгээг нийтэд хүргэх үйл ажиллагаа явуулдаг бүтэц, зохион байгуулалттай төрийн байгууллагууд нь хүний нөөцийн бодлогыг оновчтой зөв тодорхойлсон, боловсруулсан, баталгаажуулсан байдлыг хамруулав.

Аудитын арга зүй:

Аудитыг АДБОУС-100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт *MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”*, *MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”*, *MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын зарчим”*, *MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”*, *MNS 6817-8:2020 “Төрийн аудит. Нийцлийн аудит”*-ын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав.

- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Авлигын эсрэг хууль;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Байгууллагын нууцын тухай хууль;
- Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль;
- Захиргааны ерөнхий хууль;
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль;
- Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
- Төрийн болон албаны нууцын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн байгууллагын хүний нөөцийн бусад холбогдох эрх зүйн актууд.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, ахлах аудитор Т.Болор, аудитор О.Анхбаяр, Б.Наранцэцэг нар 2024 оны 09 дүгээр сарын 02-ноос 11 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:


Төрийн албаны тухай хууль нь анх 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдөр батлагдаж, 1995 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн байна.

Дээрх хуулийг 2002 оны 06 дугаар сарын 28, 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдөр тус тус шинэчлэн найруулж, 2020 оны 01 дүгээр сарын 23, 05 дугаар сарын 14, 2021 оны 01 дүгээр сарын 15, 07 сарын 02, 2022 оны 04 сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дүгээр сарын 11, 12 дугаар сарын 23, 2023 оны 01 дүгээр сарын 06, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 12 дугаар сарын 07-ны өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

2023 оны байдлаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 219 төрийн байгууллагад 128 улс төрийн, 674 төрийн захиргааны, 207 төрийн тусгай, 5750 төрийн үйлчилгээний албан хаагч ажиллаж байна.

Хүйсийн тэнцвэртэй байдлыг албан тушаалын ангиллаар авч үзэхэд төрийн улс төрийн албан хаагчдын **69.5** хувийг эрэгтэй албан хаагчид эзэлж байгаа бол үйлчилгээний албан хаагчдын **76.3** хувийг эмэгтэй албан хаагчид эзэлж байна.

Дүрслэл 1. Сэлэнгэ аймгийн төрийн албан хаагчдын 2023 оны байдлаарх хүйсийн байдал, албан тушаалын ангиллаар /тоогоор/



Эх сурвалж: Статистик мэдээллийн 1212.mn сайт

УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050”-д Монгол хүний хөгжлийг хангасан ухаалаг-тогтвортой засаглал тогтож, захиргааны оновчтой бүтэц зохион байгуулалт бүхий төрийн алба төлөвшин, цахим технологид тулгуурласан иргэн төвтэй төрийн үйлчилгээнд бүрэн шилжиж, төр хувийн хэвшил, иргэний нийгмийн хамтын ажиллагаа бүх хүрээнд өргөжин, хүний эрхийг бүрэн хангасан, шударга ёсны тогтолцоо төлөвшсөн, авлигагүй улс болохоор зорилгоо тодорхойлжээ.

БҮЛЭГ 1. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТОГТОЛЦОО БҮРДСЭН ЭСЭХ?

1.1 Төрийн байгууллагуудын хүний нөөцийн асуудлыг зохицуулж буй хууль тогтоомж, баримталж буй бодлогын зорилт, арга хэмжээ нь нэгдмэл, харилцан уялдаатай, бүх талын оролцоог хангаж чадаж байна уу

Аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулж, мөрдөөгүй байна.

1.1.1 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050”-ийн Засаглал бүлгийн 5.3-д “Цахим Монгол”, 5.4-д “Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба”, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Засаглалын бодлогын 4.1-д “Цахим Монгол төрийн шуурхай үйлчилгээ”, 4.2-д “Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба” гэсэн зорилтуудыг тус тус дэвшүүлсэн байна.

1.1.2 Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийг үндэслэн аймгийн ИТХ-ын 2020 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Засаглалын бодлогын 4.1-д *“Төрийн үйлчилгээнд ухаалаг-тогтвортой засаглалыг бэхжүүлж, чадахуйн зарчимд суурилсан хариуцлагатай, шуурхай, нээлттэй, ил тод төрийн үйлчилгээг хүргэнэ”* гэсэн зорилт дэвшүүлэн, 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.1.3 Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1¹, 53.2², Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллагуудад мөрдөгдөх *“Сэлэнгэ аймгийн 2022-2025 оны стратеги төлөвлөгөө”*-г хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй нийцүүлэн боловсруулсан байна.

1.1.4 “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1³, 21 дүгээр зүйлийн 21.1⁴, 22 дугаар зүйлийн 22.1⁵-д орон нутагт хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх аймаг, сумын чиг үүргийн талаар тусгасан байна.

1.1.5 “Орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр” чиг үүрэгт аймгийн хэмжээнд хүний нөөцийн төлөвлөлт хийж, бодлого хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, сумын түвшинд хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөлийг нь хангахаар тогтоосон байна.

1.1.6 Мэргэжилтэй хүний нөөцийг бэлтгэх, тогтвортой ажиллуулах, сургаж хөгжүүлэхтэй холбоотой хуулиар олгогдсон энэхүү чиг үүрэг нь аймаг, сумын хэмжээнд бие даан хүний нөөцийн төлөвлөлтийг хийж, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагаар тодорхойлогдож байна.

1.1.7 Дээрх хууль эрх зүй, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хүрээнд аймаг, орон нутгийн хүний нөөцийн төлөвлөлт, хөтөлбөрийг аймгийн холбогдох байгууллагуудаас батлан хэрэгжилтийг зохион байгуулж, ажиллахаар зохицуулагдсан боловч аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулж, мөрдөөгүй байна.

1.1.8 Хэдийгээр Сэлэнгэ аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг тусгайлан боловсруулж, мөрдөөгүй боловч аймгийн ИТХ-ын тогтоолоор дараах 2 хөтөлбөрийг боловсруулж, үр дүнг тооцсон байна. Үүнд:

- *2017 оны 143 дугаар тогтоолоор “Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал” аймгийн хөтөлбөрийг баталж, 2018-2022 онд 5 зорилт, 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 40 арга хэмжээг 100 хувь, 3 арга*

¹ Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна.

² Хуульд өөрөөр заагаагүй бол стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална.

³ Орон нутгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна: 20.1.5: орон нутгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр

⁴ Аймгийн чиг үүрэгт дараах асуудал хамаарна: 21.1.6: аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөр

⁵ Сумын чиг үүрэгт дараах асуудал хамаарна: 22.1.6: аймгийн хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт, ажиллах нөхцөл

хэмжээг 70 хувь, нийт 97.1 хувийн биелэлттэй тайлагнасан бол аймгийн ИТХ-ын 2020 оны 43 дугаар тогтоолоор хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн мэдээллийг хэлэлцээд 20 арга хэмжээг 100.0 хувь, 18 арга хэмжээг 70.0 хувь, 5 арга хэмжээг 40.0 хувь, нийт 75.3 хувьтай хэрэгжсэн буюу “Хангалттай” гэж дүгнэсэн байна.

- 2018 оны 17 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа” аймгийн хөтөлбөрийг баталж, 2018-2024 онд 5 зорилт, 27 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 22 арга хэмжээг 100.0 хувь, 4 арга хэмжээг 70.0 хувь, 1 арга хэмжээг 40.0 хувь, нийт 93.3 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

1.1.9 Засгийн газрын 2008 оны 67, 2018 оны 9, 2021 оны 377 дугаар тогтоолуудаар аймгийн ЗДТГ-ын бүтэц, орон тооны хязгаарыг, 2009 оны 13, 2015 оны 425, 426, 2018 оны 367 дугаар тогтоолуудаар сумдын ЗДТГ-ын бүтэц, орон тооны хязгаарыг тус тус баталсан бол аймгийн Засаг даргын 2015 оны А/475 дугаар захирамжаар сумдын ЗДТГ, тосгоны Захирагчийн албаны бүтэц, орон тоог шинэчлэн баталсан байна.

1.1.10 Аймгийн ЗДТГ-ын 2012-2023 онд батлагдсан орон тоо давхардсан тоогоор 1000 /нэг жилд дунджаар 78-104/ бол гүйцэтгэлээр 966 /нэг жилд дунджаар 76-99/ албан хаагч ажиллаж, батлагдсан орон тооны хүрээнд үйл ажиллагаа явуулж ирсэн бөгөөд төрийн албан хаагчийн тоо 78-аас 104 болж 32.0 хувиар өссөн байна.

1.1.11 Сумдын ЗДТГ-ын хувьд 2012-2023 онд батлагдсан орон тоо давхардсан тоогоор **5815** бол гүйцэтгэлээр **5704** албан хаагч ажиллаж, батлагдсан орон тооны хүрээнд үйл ажиллагаа явуулсан бөгөөд төрийн албан хаагчийн 446-аас 520 болж 13.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс/

1.1.12 Аймгийн Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын төсвийн захирагчдыг сонгон шалгаруулалтын үр дүнг үндэслэн, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн томилж, тухайн байгууллагын бүтэц, орон тооны хязгаарыг баталсан байна.

1.1.13 Аудитын явцад 2019-2023 онуудыг түүвэрлэн авч үзэхэд аймгийн Засаг дарга нь төр, төсвийн байгууллагын 8 төсвийн шууд, 29 төвлөрүүлэн захирагчийг томилж, 6 байгууллагын бүтэц, орон тоог шинээр болон шинэчлэн баталсан байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос/

1.1.14 Өөрөөр хэлбэл аймаг, сумдын ЗДТГ, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд нь Засгийн газрын тогтоол болон аймгийн Засаг даргын баталсан бүтэц, орон тооны хязгаарыг мөрдөж ажилласан байна.

1.1.15 Төрийн албаны тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2.6⁶, 66 дугаар зүйлийн 66.1.8⁷-д төрийн албаны хүний нөөцийн бодлогын хэрэгжилтэд хяналт-үнэлгээ

⁶ төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах;

⁷ төрийн албаны шинэтгэлийн бодлого, стратеги, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах;

хийж, түүний үр дүнг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж боловсруулах асуудлыг Засгийн газар, ТАЗ тус тус хариуцахаар зохицуулсан байдаг.

1.1.16 2023 онд ТАЗ-өөс томилогдсон ажлын хэсэг Сэлэнгэ аймагт ажиллаж 18 байгууллагын 435 төрийн захиргааны албан хаагчийн хувийн хэрэг, хүний нөөцийн мэдээллийн системд оруулсан мэдээллийг тулган шалгасан байна.

1.1.17 Дээрх шалгалтаар албан хаагчийн томилгоотой холбоотой 37 зөрчил илрүүлж, 31 зөрчлийг газар дээр нь арилгуулан 6 албан хаагчийн томилгооны зөрчлийг залруулах ТАЗ-ийн 2023 оны 329 дүгээр тогтоол гаргаж, хэрэгжилтийг хангасан байна.

1.2 Төрийн байгууллагын хүний нөөцийн тогтолцоо нь төрийн үйлчилгээг үр дүнтэй хүргэхэд чиглэгдэж байна уу

Төрийн байгууллагын үйлчилгээг чирээгдэлгүй, хүртээмжтэй хүргэх хүний нөөцийн тогтолцоо бүрдсэн хэдий ч төрийн албаны хүний нөөцийн хомсдол үүссэн байна

1.2.1 Төрийн албаны тухай хууль бүхэлдээ төрийн үйлчилгээг иргэдэд үр дүнтэй хүргэхэд чиглэгдэж төрийн алба, түүний хүний нөөцийн тасралтгүй байдлыг хангах зорилгоор төрийн албан тушаалд сонгон шалгаруулж томилох, түр орлон гүйцэтгүүлэх журам, төрийн албан дахь хөдөлмөрийн харилцаа, төрийн үйлчилгээний ил тод байдал /хуулийн 6,7, 11 дүгээр бүлэг гэх мэт/ зэргийг зохицуулсан байдаг.

1.2.2 Бид аудитын явцад төрийн албаны хүний нөөцийн хүрэлцээ, хангамж, төрийн үйлчилгээний ил тод байдлыг холбогдох нотлох баримтуудын хүрээнд тулган шалгаж, иргэдээс санал асуулга авч нэгтгэн, дүгнэлт өглөө.

1.2.3 Төрийн албан хаагчийн тоо бүртгэлийн мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор бүрдүүлж буй “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” /төрийн бүх шатны 219 байгууллага хүний нөөцийн мэдээлэл оруулсан/ цахим системээс харахад 2012-2023 онуудад давхардсан тоогоор аймаг, сумдын ЗДТГ-т 5815 төрийн албан хаагч ажиллахаар орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 5704 төрийн албан хаагч ажиллаж, 111 орон тоо дутуу буюу хүний нөөцийн дутагдалтай байна.

1.2.4 Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д “Төрийн албан хаагч дараах нийтлэг үүрэг хүлээнэ” 37.1.17: “Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил, үүрэг эрхлэхгүй байх”, 38 дугаар зүйлийн 38.1-д “Төрийн албан хаагч дараах нийтлэг эрх эдэлнэ”, 38.1.6: “Багшлах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх”, 38.1.7: “Хууль тогтоомжоор хориглоогүй, албан тушаалын ашиг сонирхолд харшлахгүй арга хэлбэрээр хувийн аж ахуй эрхлэх...” гэж тус тус зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл төрийн албан хаагч 38 дугаар зүйлийн 38.1.6, 38.1.7-д зааснаас бусад чиглэлээр үндсэн ажлаас гадуур ажил, үүрэг эрхлэхийг хориглосон байдаг.

1.2.5 Аудитын явцад аймаг, сумдын ЗДТГ, боловсролын салбарын нийт 99 байгууллагын 2023 оны хүний нөөцийн бүрдүүлэлт, хөдөлмөрийн харилцааг

түүвэрлэн авч үзэхэд сул ажлын байрыг нийтэд зарлан мэдээлсэн хэдий ч нөхөн бүрддэггүйгээс төрийн үйлчилгээг олон нийтэд тасралтгүй, чирэгдэлгүй хүргэх зайлшгүй шаардлагын хүрээнд сул ажлын байрыг бусад албан хаагчдаар хавсран гүйцэтгүүлж, хавсран гүйцэтгүүлсний нэмэгдлийг албан тушаалын цалингийн 10.0-80.0 хүртэлх хувиар тооцон цалин олгосон байна. Үүнд:

- *Төрийн захиргааны 60 албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж, 129,368.5 мянган төгрөгийн цалин,*
- *Төрийн үйлчилгээний 56 албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж, 162,235.7 мянган төгрөгийн цалин хөлс олгосон гэх мэт. /Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас/*

1.2.6 Хүний нөөцийн хангамж, хүрэлцээ, дутагдлаас шалтгаалан төр, төсвийн байгууллагууд, ялангуяа боловсрол, эрүүл мэндийн салбарын байгууллагууд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдийг төрийн үйлчилгээний албан тушаалд “Хөдөлмөрийн гэрээ”-ний үндсэн дээр ажиллуулж байна. Үүнд:

- *Эрүүл мэндийн 11 байгууллага 47 иргэнийг их эмч, сувилагчаар,*
- *Боловсролын 27 байгууллага 73 иргэнийг багшаар гэх мэт. /Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс/*

1.2.7. Төрийн үйлчилгээний албан тушаал болох нягтлан бодогчийн нөөц хомсдолтойгоос төрийн байгууллагын 39 нягтлан бодогч өөрийн байгууллагаас гадна 1-2 байгууллагын буюу 1 хүн 3 хүртэлх байгууллагын нягтлан бодогчийг зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр гүйцэтгэж, байгууллага тус бүр албан тушаалын цалингийн 80.0-100.0 хувьтай /үндсэн орон тооны бүтэн цалин/ тэнцэх цалин олгосон байна. Энэ Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 1.17 дахь заалтаас гадна Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь “Зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтны нийт ажлын цаг энэ хуулийн 84.4 -т заасан ажлын цагийн дээд хязгаарт багтах ёстой...”, 84 дүгээр зүйлийн 84.4 дэх “Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна” гэсэн заалтыг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас/

1.2.8 Хүний нөөцийн оновчтой хуваарилалт хийх, төрийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, хүртээмжтэй хүргэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 153, 2019 оны 149 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй "Нэг цонхны үйлчилгээ", "Төрийн үйлчилгээний нэгдсэн төв"-ийг 2019 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн операторын хэлбэрээр үйлчилгээ үзүүлдэг "Үйлчилгээний нэгдсэн төв" болгон өөрчлөн зохион байгуулсан байна.

1.3. Төрийн байгууллагын хүний нөөцийн удирдлага үр дүнтэй байна уу

Төрийн албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудын сул ажлын байрыг холбогдох хууль, журмын хүрээнд нөхөн томилоогүй бөгөөд зарим байгууллагууд сул орон тооны сонгон шалгаруулалтыг нийтэд зарлаагүй байна

1.3.1 "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Тав. Засаглал-Ухаалаг бүтэц, Зорилт 5.2. *"Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой тодорхойлох замаар чиг үүрэг, эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчилна."* гэж заасан байна.

1.3.2 Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1⁸, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2⁹, 14.6¹⁰, Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор баталсан "Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого", 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-д төрийн байгууллагын чиг үүргийн шинжилгээг шинжлэх ухааны үндэстэй иж бүрэн хийх, иргэдэд тулгарч байгаа асуудлыг шуурхай шийдвэрлэх талаар тусгасан байна.

1.3.3 Сэлэнгэ аймгийн хувьд чиг үүргийн шинжилгээг бие даан хийж байгаагүй боловч ЗГХЭГ, Швейцарын хөгжлийн агентлагийн "Төвлөрлийг сааруулах бодлогын дэмжлэг" төслийн захиалгаар орон нутгийн судлаачдын баг "Орон нутагт хэрэгжүүлэхээр заасан чиг үүргүүд, тэдгээрийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замууд: Нөхцөл байдлын судалгаа"-г Сэлэнгэ аймгийн жишээн дээр 2020 онд гүйцэтгэсэн байна.

1.3.4 Уг судалгааны ажлын үр дүнд *"Нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэг давхардсан, үйл ажиллагааг санхүүжүүлэх санхүүгийн нөөц дутагдалтай, улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс ихээхэн хамааралтай, төвөөс алслагдсан сум, багийн түвшинд иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж хангалтгүй, анхан шатанд үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хүний нөөц, түүний чадавх бэхжээгүй байгаа нь төв, орон нутгийн түвшинд чиг үүргийг дахин хуваарилж, улс, орон нутгийн төсөв хоорондын харилцааг боловсронгуй болгох замаар санхүүгийн хангалттай эх үүсвэрийг бүрдүүлэн төрийн үйлчилгээний үр ашиг, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоо, орон нутгийн бие даасан байдлыг ханган, эрх мэдлийг оновчтой хуваарилж төвлөрлийг сааруулах зайлшгүй шаардлагыг бий болгож байна"* гэсэн дүгнэлтийг хийсэн байна.

1.3.5 Дээрх судалгаанд дурдсанаар аймгийн ЗДТГ-ын ХОХБТ-ийн хэлтсийн дэд бүтэц хариуцсан мэргэжилтний чиг үүрэгт барилга, зам, газар, тээвэр, цахилгаан, дулаан, харилцаа холбооны аймгийн хэмжээний асуудлуудыг хариуцахаар албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан байдаг бол Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн өргөдөл, гомдол, шагнал хариуцсан мэргэжилтний чиг үүрэгт иргэд, байгууллагаас албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл, гомдол болон шагналын асуудлыг хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, шийдвэрлүүлэх асуудал тусгагдсан байна.

⁸ Зөвлөл дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 66.1.7: "чиг үүргийн шинжилгээ хийхэд төрийн байгууллагад мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгөх

⁹ Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 14.2.11: төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах

¹⁰ Энэ хуулийн 14.2.11-т заасан чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийх, чиг үүргийг дахин хуваарилах аргачлалыг Засгийн газар батална.

1.3.6 Гэвч дээр дурдсан албан хаагчдын хувьд тавигдах шаардлага харилцан адилгүй, мэргэжил өөр байдаг тул чиг үүргийг тэнцвэртэй дахин хуваарилах асуудал хүндрэлтэй гэж дүгнэсэн нь ч уг дүгнэлтийн мөрөөр ямар нэгэн арга хэмжээ аваагүй байна.

1.3.7 Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “*Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ... үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэгдсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна*” гэж заасны дагуу аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь тус чиг үүргийг хэрэгжүүлж байгаа хэдий ч төрийн байгууллагуудын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, бүтцийн өөрчлөлт, хөтөлбөрийн баталгаажуулалт, гүйцэтгэл, хүний нөөцөд дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

1.3.8 Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5¹¹, 23 дугаар зүйлийн 23.6¹², 23.7¹³, ТАЗ-ийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-д албан тушаалын тодорхойлолтыг хэрхэн боловсруулах, хянах, зөвшөөрөл олгох батлах, өөрчлөлт оруулах талаар зохицуулсан байдаг.

1.3.9 ТАЗ-өөс бүх аймаг, сумдын ЗДТГ, ТЕЗ-ийн эрхлэх хүрээний агентлагуудад нийтлэг байдлаар мөрдөх албан тушаалын тодорхойлолтуудыг хянаж, зөвшөөрөл олгодог бөгөөд үүнийг төрийн бүх шатны байгууллагууд албажуулж, мөрдөж ажилласан байна.

1.3.10 Харин аймгийн Эрүүл мэндийн газрын төрийн захиргааны албан тушаалын 16 тодорхойлолтыг хянаж батлуулахаар болон мэргэжлийн индекс өөрчлүүлэхээр ТАЗ-д хүргүүлснээс 6 нь шийдвэрлэгдсэн бол 10 нь өнөөг хүртэл шийдвэрлэгдээгүйгээс албан тушаалын тодорхойлолтгүй сул ажлын байрыг нээлттэй зарлах боломжгүй байна.

1.3.11 Зарим албан тушаалын тодорхойлолтын мэргэжил, мэргэшлийн шаардлагыг бусад адил түвшний албан тушаалаас хэт өндөр тавьдгаас тухайн сул ажлын байр нөхөгдөхгүй удах байдал ажиглагдаж байна. Тухайлбал Мандал сумын Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын даргын албан тушаалын мэргэшлийн шаардлагыг “магистр” байхаар /бусад төсвийн шууд захирагчдад уг шаардлага байхгүй/ баталснаас 2021 оноос хойш зарлагдсан уг сул ажлын байр өнөөг хүртэл нөхөгдөөгүй, түр орлон гүйцэтгэгчтэй байна.

1.3.12 Төрийн албан хаагчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаагаар хангах эрх зүйн хүрээнд Засгийн газрын холбогдох тогтоолуудаар баталсан төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээнээс гадна төрийн алба хаасан хугацааны, цолны, ур чадварын, зэрэг дэвийн, мэргэшлийн

¹¹ албан тушаалын тодорхойлолт” гэж тухайн албан тушаалын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх албан хаагчид тавигдах боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, ур чадварын шаардлагыг баталгаажуулсан баримт бичгийг.

¹² Төрийн захиргааны албаны албан тушаалын тодорхойлолтыг энэ хуулийн 23.5-д заасан журамд нийцүүлэн боловсруулж, төрийн албаны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн тухайн албан хаагчийг томилох эрх бүхий этгээд албан тушаал тус бүрээр батална.

¹³ Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд энэ хуулийн 23.5-д заасан тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно.

зэргийн, орон нутгийн, хөдөлмөрийн нөхцөлийн зэрэг нэмэгдэл олгох журмуудыг төрийн байгууллагууд мөрдөн ажиллаж байна.

1.3.13 Цалин хөлс, урамшууллаас гадна байгууллага бүр Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйл, “Хөдөлмөрийн дотоод журам”-д заасны дагуу холбогдох тэмдэглэлт баяраар бэлэг дурсгалын зүйл, түлээ нүүрсний хөнгөлөлт олгох, ээлжийн амралт эдлэх гэх мэтээс бусдаар орон байраар хангагдахад төрөөс дэмжлэг үзүүлэх зэрэг томоохон нийгмийн баталгаагаар хангагдаж чадахгүй байна.

1.3.14 Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”-д төрийн албан хаагчид албан томилолтын, унаа, хоолны, төрийн албан хаагчийн эрүүл мэндэд учирсан хохирлыг нөхөх төлбөр, эмчилгээний зардлыг нөхөх төлбөр зэрэг нөхөх төлбөрийг олгохоор зохицуулагдсан байдаг.

1.3.15 Дээрх журмын дагуу төрийн бүх байгууллагууд төрийн албан хаагчдад дараах нөхөх төлбөрийг олгосон байна.Үүнд:

- *Аймгийн ТЕЗ, түүний харьяа байгууллагууд унаа хоол болон албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрт 2020 онд 357,757.3 мянган төгрөг, 2021 онд 358,929.1 мянган төгрөг, 2022 онд 426,666.8 мянган төгрөг, 2023 онд 803,433.8 мянган төгрөгийг тус тус тооцож олгосон байна.*

1.3.16 Төрийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4¹⁴, 16 дугаар зүйлийн 16.1, 27 дугаар зүйлийн 27.1, 27.2¹⁵, 27.3, ТАЗ-ийн 2023 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол шатлан дэвшүүлэх сонгон шалгаруулах журам”-д сул орон тоог нөхөх, олон нийтэд мэдээлэх, захиалга хүргүүлэх, санал болгосон нэр дэвшигчийг томилох зэрэг асуудлыг зохицуулсан байдаг.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд ТАЗ-ийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлөөс зохион байгуулсан шалгалтууд, сул ажлын байрыг нөхсөн байдлыг 2020-2023 онуудаар түүвэрлэн авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- **Төрийн албаны ерөнхий шалгалт:** нийт 2002 иргэн бүртгүүлснээс 1602 иргэн шалгалтад орж, 537 иргэн тэнцсэнийг ТАЗ-ийн “Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэх тухай” 2020 оны 371, 2021 оны 106, 362, 2022 оны 263, 581, 2023 оны 91, 201, 407, 500 дугаар тогтоолуудаар тус тус нөөцөд бүртгэсэн.
- **Тусгай шалгалт:** төрийн захиргааны удирдах ба гүйцэтгэх албан тушаал болон төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаалын нийт 1086 орон тоог /давхардсан тоогоор/ зарлаж, 43 удаагийн тусгай шалгалтыг зохион байгуулан төрийн захиргааны удирдах албан тушаалын

¹⁴ сул орон тоо” гэж төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь бууруулсан, төрийн албанаас чөлөөлсөн, халсан, өөр албан тушаалд сонгогдсон, томилогдсон, эсхүл төрийн жинхэнэ албан хаагч нас барсны улмаас тухайн албан тушаалын орон тоо суларсан байхыг

¹⁵ Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.

37, гүйцэтгэх албан тушаалын 261, төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын 30 зэрэг нийт 328 сул орон тоог нөхсөн байна.

1.3.17 Аудитын явцад аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний зарим агентлаг болон сумд нь сул орон тоог нийтэд зарлан мэдээлж, сул ажлын байрыг нөхсөн байдлыг тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- **Аймгийн ЭМГ:** Тус газрын батлагдсан бүтэц, орон тоогоор төрийн захиргааны 32 албан хаагч ажиллахаас өнөөгийн байдлаар 22 ажлын байр нөхөгдөөгүй, сул байна. Үүнээс 10 албан тушаалын тодорхойлолтыг шинээр хянаж, батлуулахаар болон мэргэжлийн индекс өөрчлүүлэхээр ТАЗ-д хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүйгээс өнөөг хүртэл уг 10 сул ажлын байрыг нөхөх захиалгыг хүргүүлэх боломжгүй байна. Харин үлдсэн 12 сул ажлын байрыг нээлттэй зарлуулах зарыг ТАЗ-ийн салбар зөвлөлд хүргүүлсэн,
- **Аймгийн Боловсролын газар:** 2023 оны байдлаар төрийн захиргааны албан тушаалын 8 сул орон тооноос 1 ажлын байрыг зарлуулж, бусад 7 ажлын байрыг хавсран гүйцэтгүүлж байгаа гэх үндэслэлээр зарлуулах захиалгыг хүргүүлээгүй нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2¹⁶-т заасныг зөрчсөн байсан. 2024 онд бүх сул ажлын байрыг зарлуулах саналыг хүргүүлсэн байна. Тус газрын дарга 2022 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгож, түр орлон гүйцэтгэгчийг томилсон боловч өнөөг хүртэл уг ажлын байр нөхөгдөөгүй,
- **Аймгийн ХХААГ:** 2023 оны байдлаар төрийн захиргааны 2 сул ажлын байр байгаагаас 1 ажлын байрны албан тушаалын тодорхойлолтыг батлуулаагүй, 1 албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж байгаа гэх үндэслэлээр зарлуулаагүй,
- **Орон нутгийн өмчийн газар:** Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/587 дугаар захирамжаар 12 орон тоотой буюу төрийн захиргааны 9 албан хаагчтай байхаар орон тоо нэмэгдэж батлагдсанаас төрийн захиргааны 6 сул ажлын байрыг нөхөх захиалгыг өнөөг хүртэл хүргүүлээгүй,
- **Худалдан авах ажиллагааны газар:** Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/586 дугаар захирамжаар 10 орон тоотой буюу төрийн захиргааны 8 албан хаагчтай байхаар орон тоо нэмэгдэж батлагдсан боловч төрийн захиргааны 5 сул ажлын байрыг нөхөх захиалгыг хүргүүлээгүй,
- **Аймгийн ЗДТГ:** 2023 оны байдлаар нийт 104, үүнээс төрийн захиргааны албан тушаалын 59 орон тоо батлагдсанаас 3 сул орон тооны захиалгыг ТАЗ-ийн салбар зөвлөлд хүргүүлж, зарласан боловч нөхөгдөөгүй байна.

¹⁶ Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.

Төсвийн шууд захирагч, багийн Засаг дарга нар:

- Баруунбүрэн сумын цэцэрлэгийн эрхлэгчийг сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн Б/45 дугаар захирамжаар, Сүхбаатар сумын 4 дүгээр сургуулийн захирлыг БСШУ-ны сайдын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн Б/11 дүгээр тушаалаар түр томилсон боловч өнөөг хүртэл эдгээр ажлын байр нөхөгдөөгүй байна.
- Мандал сумын Мөнгөн хараа дуу бүжгийн чуулгын даргыг 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Б/24, Хэрх тосгоны соёлын төвийн даргыг 2022 оны 03 дугаар сарын 09-ны өдрийн Б/13, Түнхэл тосгоны соёлын төвийн даргыг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн Б/09 дүгээр захирамжаар, Хушаат сумын соёлын төвийн даргыг 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн Б/28 дугаар захирамжаар тус тус түр орлон гүйцэтгэгчээр томилсон боловч сул орон тоо өнөөг хүртэл нөхөгдөөгүй байна.
- Аудитад хамрагдсан онуудад сумдын Эрүүл мэндийн төвийн даргыг сонгон шалгаруулалтгүйгээр шууд томилсон нь ТАЗ-ийн 2013 оны 60 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”, 2019 оны 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал 2023 оныг түүвэрлэн авч үзэхэд 8 эрүүл мэндийн төвийн дарга буюу төсвийн захирагчийг шууд томилон тухайн онд **254,702.7** мянган төгрөгийн цалин олгосон байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 6-аас/
- Аудитын явцад 2023 оны байдлаар төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтнуудын сул ажлын байрыг нөхсөн байдлыг түүвэрлэн шалгахад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдийг төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаал буюу төсвийн шууд захирагчаар эргүүлэн томилдог зөрчил оршиж байна. Үүнд:
 - Мандал сумын Тарни сургууль-цэцэрлэгийн цогцолборын даргын сул ажлын байрыг зарлалгүйгээр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон Д.Зэмбээг сумын Засаг даргын 2011 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 361 дүгээр захирамжаар түр томилж, өнөөг хүртэл ажиллуулан 2023-2024 онд **45,057.5** мянган төгрөгийн цалин олгосон,
 - 2020 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгож, төрийн албанаас чөлөөлөгдсөн М.Баярбаатарыг аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн Б/30 дугаар захирамжаар аймгийн Нэгдсэн музейн даргаар томилсон боловч өнөөг хүртэл сул ажлын байрыг зарлаагүй, сонгон шалгаруулалт явуулаагүй бөгөөд 2023-2024 онд **30,591.5** мянган төгрөгийн цалин олгосон,
 - Мандал сумын Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Б/73 дугаар захирамжаар 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Ж.Бүрэнбуянг, 2023 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн Б/51 дүгээр захирамжаар 2 дугаар сургуулийн захирал П.Сэлэнгийг өндөр насны тэтгэвэрт гарах үндэслэлээр тус тус ажлаас чөлөөлсөн байна. Гэвч Ж.Бүрэнбуянг 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Б/74 дүгээр захирамжаар түр орлон

гүйцэтгэгчээр эргүүлэн томилж 2023-2024 онд **28,272.6** мянган төгрөгийн цалин, П.Сэлэнгийг 2023 оны 08 дугаар сарын 24-ны өдрийн Б/59 дүгээр захирамжаар түр орлон гүйцэтгэгчээр буцаан томилж 2023-2024 онд **27,973.1** мянган төгрөгийн цалин тус тус олгосон байна.

- Сэлэнгийн долгио чуулгын дарга Д.Уранбилэгийг аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн Б/39 дүгээр захирамжаар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөр тасалбар болгон чөлөөлөхөөр шийдвэрлэж, тэтгэмжийг олгосон боловч өнөөг хүртэл ажиллуулж, уг хугацаанд **18,723.7** мянган төгрөгийн цалин олгосон байна.
- Аудитын явцад 2020-2023 оныг түүвэрлэн авч үзэхэд БИНХ хуралдаж, багийн Засаг даргад нэр дэвшүүлээгүй байхад 8 сумын 15 багийн Засаг даргыг түр орлон гүйцэтгэгчээр болон шууд томилж, 2023 онд төсвөөс **177,954.2** мянган төгрөгийн цалин олгосон байна. Энэ нь МУЗЗНДНТУТХ-ийн 32 дугаар зүйлийн 32.8.4, 56 дугаар зүйлийн 56.5.2-т заасныг зөрчсөн байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 7-оос/
- Төрийн жинхэнэ албаны удирдах болон гүйцэтгэх албан тушаалд төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй иргэдийг түр томилсон нь Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.2¹⁷, 27.1.3¹⁸, 27.2¹⁹-д заасныг тус тус зөрчсөн байна. Үүнд:
 - Шаамар сумын ИТХ-ын нарийн бичгийн даргаар Б.Даариймааг 2021 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 25 дугаар тушаалаар түр томилж, 2023-2024 онд төсвөөс **60,798.0** мянган төгрөгийн цалин олгосон байна. /ТАЗ-ийн 2023 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 89 дүгээр тогтоолоор тусгай шалгалт өгч тэнцсэн Ч.Эрдэнэжаргалыг Шаамар сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн боловч томилоогүй/
 - Цагааннуур сумын ЗДТГ-ын бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнээр П.Энхтүвшинг 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн Б/25 дугаар тушаалаар, хүнс, жижиг дунд үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтнээр Б.Шагдарсүрэнг 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Б/06 дугаар тушаалаар тус тус хөдөлмөрийн гэрээ байгуулж түр томилон 2023-2024 онд төсвөөс **65,066.7** мянган төгрөгийн цалин олгосон байна.
 - Шаамар сумын ЗДТГ-ын бэлчээр, газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтнээр Н.Булганыг 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Б/36 дугаар тушаалаар түр томилж, 2023-2024 онд төсвөөс **30,362.7** мянган төгрөгийн цалин олгосон байна.
 - Мандал сумын Түнхэл тосгоны Захирагчийн албаны нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнээр Т.Золжаргалыг 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн Б/33 дугаар тушаалаар түр томилж, 2023-2024 онд

¹⁷ төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас болон холбогдох бусад төрийн байгууллагад ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас;

¹⁸ төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх болон туслах албан тушаалын сул орон тоог энэ хуулийн 27.1.2-т заасны дагуу нөхөн боломжгүй бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаа иргэдээс

¹⁹ Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.

төсвөөс 38,142.9 мянган төгрөгийн цалин олгосон. /Уг албан тушаалын болон төрийн захиргаа, хууль эрх зүй хариуцсан мэргэжилтний сул орон тооны захиалгыг өнөөг хүртэл хүргүүлээгүй/

- *Мандал сумын ЗДТГ-ын эдийн засаг, статистикийн асуудал хариуцсан мэргэжилтнээр Б.Батхишигийг 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Б/33 дугаар тушаалаар түр томилж, 2023-2024 онд төсвөөс 48,469.2 мянган төгрөгийн цалин олгосон. /ажлын байрны тодорхойлолтыг боловсруулж, батлуулаагүйгээс сул орон тоог зарлаагүй/*
- *Мандал сумын ЗДТГ-ын хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнээр Ч.Хишигсүрэнг 2024 оны 03 дүгээр сарын 04-ны өдрийн Б/07 дугаар тушаалаар томилж, 2024 онд төсвөөс 19,353.3 мянган төгрөгийн цалин олгосон гэх мэт.*

1.3.18 Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1²⁰, 8.2²¹, 8.3²²-т төрийн албыг үр дүнтэй удирдах, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад чиглэсэн стандарттай байна гэж заасан боловч төрийн албаны стандартыг боловсруулж батлаагүй байна.

1.3.19 Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1²³, 50.2²⁴-т төрийн албан хаагчийг хууль бусаар томилсон, чөлөөлснөөс төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, хэрхэн хяналт тавих талаар зохицуулсны дагуу ТАЗ-ийн салбар зөвлөлөөс 2022-2024 онуудад хууль бусаар халсан, чөлөөлснийг тогтоосон иргэний хэргийн шүүхийн тогтоолын судалгаа /3 иргэнд холбогдох/-г гаргаж ТАЗ-д хүргүүлсэн байна.

1.3.20 Харин төрийн албан хаагчийн эрх зөрчигдөж хууль бусаар чөлөөлсөн нь иргэний хэргийн шүүхийн шийдвэрээр тогтоогдож, захиргааны байгууллагад учирсан хохирлыг буцаан төлүүлсэн эсэхийг /Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлд заасны дагуу/ Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газраас 2020-2023 онд хийгдсэн санхүүгийн тайлангийн аудитаар тулган шалгаж, дараах зөрчлийг илрүүлж, шийдвэрлэсэн байна. Үүнд:

- *12 байгууллагын 13 албан хаагчийг ажил олгогчийн буруугаас ажлаас чөлөөлснөөс нийт 62,136.8 мянган төгрөгийн цалин, НДШ, ХХОАТ-ыг нөхөн төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан бөгөөд 43,630.2 мянган төгрөгийг тухайн байгууллагын төсвөөс олгон, 4,985.4 мянган төгрөгийг гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлсэн бол 13,521.3 мянган төгрөгийг барагдуулаагүй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:*

Хүснэгт 1. Гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй хохирол

²⁰ Төрийн албаны стандарт нь төрийн албыг үр дүнтэй удирдах, төрийн байгууллага, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг оновчтой зохион байгуулахад чиглэнэ.

²¹ Төрийн албаны стандарт нь төрийн байгууллага чиг үүргээ, төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн менежментийн үйл ажиллагаанд тавих шаардлагыг тогтооно.

²² Төрийн албаны стандартыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу боловсруулан баталж, мөрдүүлнэ.

²³ Иргэнийг, эсхүл улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагчийг төрийн албанд хууль бусаар томилсон, чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ.

²⁴ Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана.

№	Нэхэмжлэгч	Албан тушаал	Хариуцагч байгууллага	Барагдуулаагүй мөнгөн дүн /мян.төг/
1	О.Мөнхцэцэг	Баруунбүрэн сумын ЗДТГ-ын харьяа зочид буудлын ажилтан	Баруунбүрэн сумын ЗДТГ	1,790.0
2	Б.Наранцацрал	МСҮТ-ийн эмч	Сэлэнгэ аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв	2,995.4
3	С.Мягмартогтох	Шаамар сумын ИТХ-ын дарга	Шаамар сумын ИТХ	4,158.2
4	Б.Бадамжаргал	Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэгийн манаач	Сэлэнгэ аймгийн Хушаат сумын 1 дүгээр цэцэрлэг	2,336.9
5	Б.Баярмаа	Баянгол сумын ЭМТ- ийн дарга	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын ЗДТГ	2,240.8
	Нийт			13,521.3

Эх сурвалж: Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын судалгаа


1.3.21 Албан тушаалтныг төрийн албанаас үндэслэлгүй чөлөөлсөн, томилсонтой холбогдуулан аймгийн ТАЗ-ийн салбар зөвлөлд 2021 онд 5, 2022 онд 2, 2023 онд 10 зэрэг сүүлийн 3 жилд нийт 17 өргөдөл, гомдол ирснийг хуулийн хүрээнд тулган шалгаж, 9 өргөдлийг шийдвэрлэж хариуг хүргүүлсэн бол тус салбарт хамааралгүй 4 өргөдлийг буцаан, 4 өргөдлийг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх хариу хүргүүлсэн байна.

1.3.22 Төрийн албан хаагчийн нэгдсэн тоо бүртгэлийг хөтөлж, улсын нэгдсэн сан бүрдүүлэх, төрийн албаны төлөв байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мэдээллийг бүрдүүлэх зорилгоор Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-ын дагуу уг системд 2023 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 6759 албан хаагч бүртгэлтэй байна.

1.3.23 Аудитын явцад ХНУМТ цахим системийн ашиглалтыг аймгийн Засаг дарга даргын зүгээс удирдлагыг нь томилдог 10 байгууллагын 78 албан хаагчийг түүвэрлэн газар дээр нь тулган баталгаажуулахад дараах байдалтай байна. Үүнд:

- *Төрийн албан хаагчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, албан тушаалын ангилал, шатлал, зэрэглэл болон цалин хөлс тооцоолоход шаардагдах мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүрд өөрчлөлтийг ХНУМТ системд үнэн зөв, бүрэн гүйцэт оруулснаар уг системээс “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем”-д мэдээлэл дамжуулж, албан хаагчдын цалинг “ТАЦНС”-ээр бодогдохоор зохицуулагдсантай холбоотойгоор түүвэрт хамрагдсан байгууллагууд нь дээрх мэдээллүүдийг бүрэн гүйцэт мэдээлж хэвшсэн байна. Энэ нь цалингийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэлд хяналтыг уг системээр дамжуулан хэрэгжүүлж байна.*
- *ХНУМТ цахим системд байршуулсан мэдээллийг түүвэрлэн шалгах явцад албан хаагчдын хувийн мэдээлэл, ур чадвар, боловсрол, ажил эрхлэлт гэх мэт мэдээллүүдийг дутуу болон зөрүүтэй болон огт оруулаагүй зөрчлүүд оршиж байна. Үүнийг дүрслэлээр харуулбал:*

Дүрслэл 2. ХНУМТ системд албан хаагчдын мэдээллийг оруулсан байдал /хувиар/



1.3.24 Дүрслэлээс харахад түүвэрлэсэн байгууллагууд нь дунджаар нийт мэдээллийн 68.0 хувийг бүрэн оруулсан бол 17.0 хувийг дутуу оруулж, 15.0 хувийг огт оруулаагүй буюу ХНУМТ системд албан хаагчдын холбогдох мэдээллийг оруулсан байдал хангалтгүй байна.

1.3.25 ХНУМТ цахим системээр дамжуулан төрийн албан хаагчдын мэдээллийн санг бүрдүүлснээс гадна төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагаанд ашиглагдаж буй ERP, Able зэрэг системүүдэд мэдээллийг байршуулсан байна.

1.3.26 ХНУМТ системээс төрийн албаны цалингийн нэгдсэн системд цалин хөлсний мэдээлэл бүрэн татагдаж байгаа бол нэгдсэн тайлан, мэдээ татагддаггүй, албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээг оруулах боломжгүй зэргээр уг системийн хөгжүүлэлт хангалтгүй байна.

1.3.27 Засгийн газрын 2019 оны 74 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-д хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- *Төрийн албаны салбар зөвлөл: ... бусад төрийн бүх байгууллагыг тоо бүртгэл хөтлөх талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавих; ... өөрийн харьяа байгууллагуудын тоо бүртгэл хөтлөх ажилд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах,*
- *Төрийн бүх шатны байгууллагын төсвийн шууд захирагч: ХНУМТ цахим системийн мэдээллийг тогтоосон хугацаанд оруулах ажлыг удирдлагаар хангаж, хяналт тавих гэх мэт.*

1.3.28 Аймгийн ТАЗ-ийн салбар зөвлөлд ХНУМТ системд нэвтрэх эрхийг олгосон боловч байгууллага тус бүрээр мэдээллийг үнэн зөв оруулж байгаа эсэхэд хяналт тавих боломж бүрдээгүй байна.

1.3.29 Аймгийн Засаг дарга, удирдлагыг нь томилдог хэлтэс, агентлагийн ХНУМТ цахим системийн мэдээлэл оруулсан байдалд төсвийн шууд захирагчдын зүгээс хяналт хэрэгжүүлээгүй байна.

1.3.30 Харин 2023 онд ТАЗ-өөс Сэлэнгэ аймагт хийсэн шалгалтын хүрээнд аймгийн салбар зөвлөлийн гишүүдтэй хамтран 34 байгууллагын бүх албан хаагчийн мэдээллийг тулган баталгаажуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, мэдээллийг шинэчлэн засварласан байна.

БҮЛЭГ 2. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТОЛЦОО НЬ САЙН ЗАСАГЛАЛЫГ БИЙ БОЛГОЖ БАЙНА УУ?

2.1 Иргэндээ үйлчилдэг мэргэшсэн, чадварлаг, ил тод төрийн алба төлөвшсөн байна уу

Иргэнд үйлчилдэг мэргэшсэн, чадварлаг, ил тод төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор төрийн албан хаагчдыг олон тооны сургалтад хамруулж байгаа хэдий ч үр дүнг үнэлж, тооцохгүй байна.

2.1.1 Төрийн албыг мэргэшсэн чадварлаг албан хаагчдаар бэхжүүлэх зорилгын хүрээнд ЗГХЭГ болон ТАЗ-ийн даргын 2019 оны 37/33 дугаар хамтарсан тушаалаар “Мэргэшүүлэх багц сургалтын агуулга, хөтөлбөр”, Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийг тус тус баталсан байна.

2.1.2 Уг хөтөлбөрийн дагуу Удирдлагын академиас зохион байгуулж буй мэргэшүүлэх багц сургалтуудад 2020-2023 онуудад аймгийн хэмжээнд нийт **204** төрийн албан хаагч хамрагдсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. Удирдлагын академиас зохион байгуулсан мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан байдал

Сургалтын төрөл	2020	2021	2022	2023
Анх томилогдсон албан хаагчдын чиглүүлэх сургалт	12	0	15	15
Мэргэшүүлэх дунд хугацааны сургалт	8	10	11	0
Мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт	8	16	8	14
Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалт	48	4	8	16
Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх сургалт	3	3	2	2
Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх сургалт	1	0	0	0
	80	33	44	47

2.1.3 Хэдийгээр төрийн албан хаагчдын мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлж байгаа ч Удирдлагын академиас аймагт жилд дунджаар 50 хүрэхгүй албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад хамруулах эрх өгч байгаа нь нийт жинхэнэ албан хаагчдын дүнд эзлэх хувийн жин хангалтгүй байна.

2.1.4 Төрийн албаны тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах, хүний нөөцийг бэхжүүлэх зорилгоор бүх шатны төрийн байгууллагууд дотооддоо болон мэргэжлийн бусад байгууллагаас зохион байгуулсан танхимын, ZOOM, Teams зэрэг платформуудыг ашиглаж хийсэн цахим сургалтуудад 2020-2023 хооронд давхардсан тоогоор 12501, жилд дунджаар 3125 албан хаагчийг хамруулсан байна.

Хүснэгт 3. Мэргэжлийн болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагдсан байдал /тоогоор/

Сургалтын төрөл	2020	2021	2022	2023	НИЙТ
Засгийн газрын зорилтот сургалт	60	497	425	0	982
Удирдлагын академийн богино хугацааны сургалт	111	635	112	890	1748
Мэргэжлийн бусад байгууллагын сургалт	785	5652	1514	1820	9771
Дүн	956	6784	2051	2710	12501

2.1.5 ТАЗ-өөс төрийн албан хаагчдын харилцаа, хандлага, ажлын үр дүн, гүйцэтгэл, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн, шинэ мэдлэг, мэдээллийг түгээх зорилгоор 2021 оноос эхлэн долоо хоног бүрийн “Пүрэв гараг”-т **“7:4:10”** нэртэй ZOOM вебинарыг тогтмол зохион байгуулж байна. Уг сургалтад Сэлэнгэ аймгийн төрийн байгууллагуудаас давхардсан тоогоор 2021 онд 5213, 2022 онд 6855, 2023 онд 14224 төрийн албан хаагч хамрагдсан дүн мэдээтэй тайлагнасан байна.

2.1.6 Төрийн үйлчилгээг цахимжуулах бодлогын хүрээнд хүний нөөцийг бэлтгэх зорилгоор аймгийн ЗДТГ, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран “Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх төрийн үйлчилгээний нэгдсэн портал системийг нэвтрүүлэх” сургалтыг 2020 онд, уг системийн “*2 шатлалт үйлчилгээ нэвтрүүлэх*” сургалтыг 2022 оны, “*операторуудыг чадавхжуулах*” сургалтыг 2023 онд тус тус зохион байгуулж, аймаг болон сумдад уг системийг хариуцан ажилладаг “Төрийн үйлчилгээний оператор” 17 албан хаагч, “ХУРДАН” төвийн 5 албан хаагч зэрэг нийт **22** албан хаагчийг сургаж, бэлтгэсэн байна.

2.1.7 Дээр дурдсанчлан төрийн албан хаагчдыг мэдлэг, ур чадвар дээшлүүлэх сургалтад тогтмол хамруулж, төсвөөс тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа боловч сургалтууд нь албан хаагчийн ажлын үр дүн, гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж байгаа талаар тодорхой **судалгаа, үнэлгээ хийдэггүй**, төрийн байгууллагын үйл ажиллагааны тайланд тэдэн албан хаагч сургалтад хамруулсан гэсэн ерөнхий байдлаар тайлагнаж байна.

2.1.8 Төрийн албан хаагчдын сургалтад шаардагдах зардлыг Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тогтоолоор батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ын “*Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх*” зардалд тусган санхүүжүүлсэн байна.

2.1.9 “*Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх*” зардлын сүүлийн 4 жилийн санхүүжилтийг 17 сумын ЗДТГ-ын жишээн дээр түүвэрлэн авч үзэхэд 2020 онд 6,061.9 мянган төгрөг зарцуулж байсан бол 2023 онд 21,439.9 мянган төгрөг болж **3.5 дахин** өссөн байна.

Дүрслэл 3. “Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх” зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл / мянган төгрөгөөр /



Эх сурвалж: 2020-2023 оны ТЕЗ-ын санхүүгийн тайлан

2.1.10 Дүрслэлээс харахад сумдын ЗДТГ-ууд 2020, 2021 онуудад төрийн албан хаагчийг мэргэшүүлэх, сургах зардалд 1 сум дунджаар 300.0 мянган төгрөгийг зарцуулж байсан бол 2023 онд 1200.0 мянган төгрөг болж, 2020 оноос 4 дахин өссөн байна.

2.1.11 Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу сэлгэн, шилжүүлэн ажилласан байдлыг аймаг, сумдын ЗДТГ-ын жишээн дээр 2020-2023 оныг түүвэрлэн авч үзэхэд төрийн албан хаагчийг сэлгэн ажиллуулаагүй бол **18** албан хаагчийг шилжүүлэн ажиллуулсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 4. Төрийн албан хаагчдыг сэлгэн болон шилжүүлэн ажилласан байдал /тоогоор/

Он	Сэлгэн ажиллуулсан		Шилжүүлэн ажиллуулсан	
	Байгууллага	Албан хаагч	Байгууллага	Албан хаагч
2020	-	-	2	2
2021	-	-	3	3
2022	-	-	3	3
2023	-	-	5	10
Дүн	-	-	13	18


2.1.12 Дадлага, туршлагатай олон жил ажилласан төрийн жинхэнэ албан хаагчдыг өөр хооронд нь сэлгэн ажиллуулахгүй байгаа нь албан хаагчийн мэдлэг, ур чадвар, туршлагыг үр өгөөжтэй ашиглах боломжийг алдагдуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлж байна гэж дүгнэж байна.

2.1.13 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлд нийт 6 түвшинд хүйсийн төлөөллийн доод хязгаар (квот) тогтоосноос 4 квотыг түүвэрлэж үзэхэд 3 нь буюу 75.0 хувь нь **хангагдаагүй** байна. Үүнд:

- Албан ёсны статистикийн мэдээгээр 2023 оны байдлаар Сэлэнгэ аймгийн **246** төрийн байгууллагуудад нийт **6759** албан хаагч ажиллаж байгаагаас 4386 албан хаагч буюу **74.2** хувийг эмэгтэй албан хаагч эзэлж байгаа нь дээрх хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-т “Төрийн ба төсөвт байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл илт давамгайлсан тохиолдолд хүйсийн **40:60** гэсэн харьцаа бүхий тэнцвэрт байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх бодлого, арга хэмжээг хүний нөөцийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх ...” гэсэн заалтыг зөрчиж, тогтоосон квотыг хангахгүй байна.

- Төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудын хүйсийн байдлыг сумдын ИТХ, ЗДТГ-ын жишээн дээр үзэхэд нийт албан хаагчдын **35.3 хувь** нь эрэгтэй албан хаагч байгаа нь хуулийн 10.1.2 дахь “*төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл ..., аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх*” гэсэн заалтыг зөрчиж, тогтоосон квотыг **хангахгүй** байна.

Дүрслэл 4. Сумдын ЗДТГ-ын төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудын хүйсийн байдал / тоогоор/



- 17 сумын Засаг дарга нараас **5.9 хувь** нь буюу 1 эмэгтэй байгаа нь хуулийн 10.1.2 дахь “*томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл ..., суманд 25 хувиас ..., доошгүй байх*” гэсэн заалтаар тогтоосон квотыг **хангахгүй** байна.
- Харин аймгийн хэмжээнд 2023 оны байдлаар **57** багийн Засаг дарга ажиллаж байгаагийн 21 нь буюу **36.8 хувь** нь эмэгтэй байгаа нь хуулийн 10.1.2 дахь “*томилогдох төрийн улс төрийн албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл ..., хороонд 30 хувиас ..., доошгүй байх*” гэсэн заалтаар тогтоосон квотыг **хангаж** байна.

2.1.14 Хөгжлийн бэршээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээр Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2-т заасан “*Өмчийн төрөл, хэлбэрээс үл хамаарч 25 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нийт ажлын байрныхаа дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулна*” заалтын хэрэгжилт хангагдаж буй эсэхийг аймаг, сумын ЗДТГ, тосгоны Захирагчийн албаны нийт **24** байгууллагын 2013-2023 оны хүний нөөцийн мэдээллээс дүгнэхэд 2015 оноос бусад хугацаанд дээрх хуулийн заалтын хэрэгжилтийг **хангаж** ажилласан байна.

Дүрслэл 5. Төрийн байгууллагад хэмжээнд ажилласан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа /тоогоор/



2.2 Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран авах нөхцөл боломж бүрдсэн үү

2020-2023 онуудад Сэлэнгэ аймаг нь 73 төрийн үйлчилгээг E-Mongolia системд холбож, операторын үйлчилсэн байна

2.2.1 Иргэд төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран авах нөхцөл боломжийг бүрдүүлэх бодлогын хүрээнд төрийн үйлчилгээний нэгдсэн систем E-Mongolia нь 2020 оны 10 дугаар сарын 01-ээс нээгдэж, иргэдэд төрийн үйлчилгээг цахимаар хүргэж эхэлсэн байна.

2.2.2 Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас гаргасан “Аймгуудын цахим шилжилтийн тайлан 2023”-д дурдсан төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д холбосон үйлчилгээний тоог аймаг бүрээр харьцуулж үзэхэд Сэлэнгэ аймаг нь **73** төрийн үйлчилгээг цахимжуулж, уг системд холбосон байна.

2.2.3 ЦХИХХ-ны сайдын 2023 оны А/02 тушаалаар “Төрийн цахим үйлчилгээг иргэдэд хурдан шуурхай, хүндрэл чирэгдэлгүй хүргэх, иргэдийг мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах” чиг үүрэг бүхий Сэлэнгэ аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийг **5** орон тоотойгоор байгуулж, төрийн үйлчилгээний “ХУРДАН” төвийг 2023 оны 06 дугаар сарын 12-нд аймгийн нэгдсэн цэгийн үйлчилгээний төвд байгуулсан бол 2 дахь салбарыг аймгийн нэгдсэн эмнэлгийн байранд байгуулсан байна.

2.2.4 Уг төв нь төрийн үйлчилгээ үзүүлэх шат дамжлагыг цөөлж нэг дороос лавлагаа тодорхойлолтын 94 үйлчилгээ, 35 байгууллагын 485 төрлийн үйлчилгээ зэрэг нийт 579 төрлийн үйлчилгээг үзүүлдэг бөгөөд 2023 оны жилийн эцсийн байдлаар Сүхбаатар сумын **9517** иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

2.2.5 Харин аймгийн төвөөс бусад сумдад цахим хэлбэрээр операторын горимоор 2020 онд 9166, 2021 онд 5084, 2022 онд 34059, 2023 онд 6820 зэрэг нийт **55129** иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.

2.2.6 Засгийн гарын 2019 оны 149 дүгээр тогтоолын 1-т “..., бүх сумдад “Үйлчилгээний нэгдсэн төв” байгуулж иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт

даалгасугай”, 3-т “...”Үйлчилгээний нэгдсэн төв”-д ажиллах байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг холбогдох ..., аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж...” гэж заасан байна.

2.2.7 Гэвч төрийн үйлчилгээг сумдад цахим хэлбэрээр хүргэх албан хаагч болох операторыг 4 сум орон тоогоор ажиллуулж байгаа бол 6 сум 20-40 хувийн цалингийн нэмэгдэл өгч хавсран гүйцэтгүүлж, 6 сум цалингүйгээр хавсруулан гүйцэтгүүлэхээр шийдвэрлэн байна.

2.2.8 Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж байгаатай холбоотойгоор цаашид зарим чиг үүргийн давхардлыг арилгах, зарим орон тоог нэгтгэх зэргээр орон тоог цөөлөх боломжтой хэдий ч сумд нь “Төрийн үйлчилгээний оператор”-ын чиг үүргийг орон тоо нэмэх, нэмэгдэл цалин олгож, хавсран гүйцэтгүүлэх зэргээр төсөвт ачаалал учрах байдлаар шийдвэрлэсэн байна.

2.2.9 Төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран цахимаар авч чадаж байгаа эсэх, төрийн үйлчилгээний шат дамжлага цөөрч, хүнд суртал буурсан эсэх талаар аудитын явцад **792** иргэнээс цахим хэлбэрээр судалгаа авахад дараах үр дүн гарсан байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээг орон зайнаас үл хамааран цахимаар авч чадаж байна уу? гэсэн асуултад 475 иргэн буюу **60** хувь нь “Тийм” гэсэн хариулт өгсөн.
- Төрийн үйлчилгээ цахимд шилжсэнээр төрийн үйлчилгээний шат дамжлага цөөрсөн үү? гэсэн асуултад 476 иргэн буюу **60.1** хувь нь “Тийм” гэсэн хариулт өгсөн.
- Төрийн үйлчилгээ цахимд шилжсэнээр төрийн албаны хүнд суртал буурсан уу? гэсэн асуултад 431 иргэн буюу **54.4** хувь нь “Тийм” гэсэн хариулт тус тус өгсөн байна.

2.2.10 Өөрөөр хэлбэл цахим технологи ашиглан иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх тогтолцоог боловсронгуй болгож, иргэд төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр хялбараар авах нөхцөл бололцоог бүрдүүлсэн нь төрийн албаны шат дамжлага, хүнд суртлыг бууруулсан байна.

2.2.11 Харин “Орон нутагт төрийн үйлчилгээ жигд хүртээмжтэй байж чадаж байна уу?” гэсэн асуултад 788 иргэнээс санал асуулга авахад 421 иргэн буюу 53.4 хувь нь “Үгүй” гэсэн хариулт өгсөн байна. Энэ нь цахим хэлбэрт шилжүүлсэн төрийн үйлчилгээний тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг харуулж байна.

2.3 Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдалд иргэд сэтгэл ханамжтай байна уу

Иргэдийн 52.5 хувь нь төрийн байгууллагын үйлчилгээг ил тод, нээлттэй байна гэж үзсэн байна

2.3.1 Сайн засаглалын зайлшгүй нэг шинж нь төрийн үйлчилгээг нийтэд ил тод, нээлттэй байлгах явдал юм.

2.3.2 Төрийн албаны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1²⁵, 7 дугаар зүйлийн 7.1²⁶, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 1.1²⁷, 8 дугаар зүйлийн 8.1²⁸, 8.8²⁹-д төрийн албаны ил тод байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, ил тод байх зарчим, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод байлгах талаар зохицуулсан байдаг.

2.3.3 Дээрх хууль эрх зүйн актын хүрээнд цаг хугацаа, орон зайнаас үл хамааран иргэд төрийн үйлчилгээг хүртэх, төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах боломжийг нэмэгдүүлэх, хялбаршуулах зорилгоор ухаалаг утсанд зориулсан “Нээлттэй Сэлэнгэ” аппликейшнийг 2017 оноос нэвтрүүлсэн байна.

2.3.4 Уг аппликейшнд аймгийн ЗДТГ, Засаг даргын эрхлэх хүрээний агентлагуудаас үзүүлэх төрийн үйлчилгээний төрөл, бүрдүүлэх баримт бичиг, төлбөр хураамжийн талаарх мэдээллийг багтаасан “Танд үйлчилье” хэсгийг бий болгож, аймгийн цахим хуудсанд буй мэдээ, мэдээллийг давхар байршуулж иргэдэд хүргэсэн байна.

2.3.5 Төрийн бүх шатны байгууллагууд хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг шилэн дансны болон байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан нийтэд ил тодоор түгээж хэвшсэн байна. Тухайлбал:

- *Аймгийн ЗДТГ нь байгууллагын эрхэм зорилго, бүтэц, нэгжүүдийн үндсэн чиг үүрэг, УИХ, Засгийн газрын шийдвэр, аймгийн ИТХ, Засаг дарга, ЗДТГ-ын даргын шийдвэр, төрийн захиргааны албан хаагчийн нийтлэг эрх, үүргийг нээлттэй байдлаар байршуулсан байна.*
- *2023 онд аймгийн албан ёсны цахим хуудсаар 200, пейж хуудсаар 360 удаагийн мэдээллийг бэлтгэн “Цаг үе үйл явдлын мэдээ” цэсийг шинэчилсэн байна.*

2.3.6 Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг тооцоолох зорилготой “Цахим ил тод байдлын индекс”-ын судалгааг IRIM судалгааны хүрээлэнгээс хийхэд Сэлэнгэ аймгийн сүүлийн 5 жилийн индексийн түвшин дараах байдалтай байна. Үүнд:

Дүрслэл 6. Сэлэнгэ аймгийн цахим ил тод байдлын түвшин /хувиар/


²⁵ ... төрийн албаны мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн албаны төв байгууллага, төрийн албан хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

²⁶ Төрийн албанд ... зарчмаас гадна дараах зарчмыг баримтална: 7.1.6: ил тод байх

²⁷ ... төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоход оршино.

²⁸ Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.

²⁹ Мэдээлэл хариуцагч энэ хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6-д заасан байнга ил тод, нээлттэй байлгах мэдээллийг олон нийтэд хүргэхдээ цахим хуудас, мэдээллийн самбар, мэдээллийн бусад хэрэгсэл ашиглана.



2.3.7 Дээрх дүрслэлээс харахад Сэлэнгэ аймгийн цахим ил тод байдлын индекс 2019 онд **74.4** хувь буюу “Хангалттай” байсан бол 2021 онд **48.9** хувь буюу “Хангалтгүй” түвшинд хүрч буурсан, 2023 онд **69.7** хувьд хүрч “Хангалттай” түвшинд хүрсэн байна.

2.3.8 Аудитын гүйцэтгэлийн үе шатанд Google.forms ашиглан 793 иргэнээс Сэлэнгэ аймгийн төрийн байгууллагуудын үйлчилгээ нь иргэдэд ил тод, нээлттэй байгаа эсэх талаарх санал асуулга авч, нэгтгэн дүгнэж үзэхэд санал асуулгад оролцсон иргэдийн **52.5** хувь нь төрийн байгууллагын үйлчилгээг ил тод, нээлттэй байна гэж үзсэн байна.

2.3.9 Төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх бодлогын хүрээнд төрийн байгууллагуудын өөр хоорондын уялдаа холбоог сайжруулах нь зайлшгүй юм.

2.3.10 Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн урсгалыг түргэтгэх зорилгоор И-Монгол Академи УТҮГ-аас 2018 онд төрийн мэдээлэл солилцооны “ХҮР” систем, 2021 онд төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP), 2022 онд албан бичиг солилцооны дундын систем (DOCX) зэрэг системүүдийг нэвтрүүлсэн байна.

2.3.11 2023 оны байдлаар Сэлэнгэ аймагт төрийн болон төрийн оролцоотой 246 байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас “Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн(ERP)” системд 174 байгууллага холбогдсон бөгөөд албан бичиг боловсруулах, мэдээлэл, файл солилцох, хурал, зөвлөгөөн хийх зэргээр байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна.

2.3.12 “Албан бичиг солилцооны дундын систем (DOCX)”-д тус аймгийн **72** төрийн байгууллага буюу нийт байгууллагын **29.3** хувь нь холбогдон албан бичгийг цахим гарын үсгээр баталгаажуулан цахимаар илгээн, хүлээн авч цаг хугацаа хэмнэн ажиллаж байна.

2.3.13 Дээрх цахим системүүд нэвтэрснээр төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирч, иргэд төрийн үйлчилгээг цаг алдалгүй, түргэн шуурхай авах боломж бүрдсэн боловч ERP, DOCX зэрэг системүүдэд Сэлэнгэ аймгийн төрийн болон төрийн оролцоотой, төсөвт байгууллагууд бүрэн холбогдоогүй байна.

2.3.14 Аудитын явцад иргэдээс авсан санал асуулгад 793 иргэн оролцож “Төрийн байгууллагуудын үйл ажиллагаа уялдаа холбоо хангагдаж чадаж байна уу гэсэн

асуултад судалгаанд оролцогчдын **52.2 хувь** нь “Тийм”, **47.8 хувь** нь “Үгүй” гэсэн хариулт өгсөн буюу иргэдийн олонх нь төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангагдаж байна гэж дүгнэсэн байна.

2.3.15 Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталж, 2017 оны 89 дугаар болон 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсан *“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”*-аар төрийн байгууллагуудын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэж байна.

2.3.16 Уг журмын 9.6³⁰-д заасны дагуу ЗГХЭГ-ын захиалгаар IRIM судалгааны хүрээлэнгээр *“2019 оны хэрэглэгчийн үнэлгээ”, “2022 оны төрийн бодлого, үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа”* сэдвээр судалгаа хийлгэхэд Сэлэнгэ аймгийн хэрэглэгчийн үнэлгээ **68.1** хувь, сэтгэл ханамжийн дүн **65.2** хувь буюу тус тус аймгуудын дунджаас дээгүүр үнэлэгдсэн байна.

2.3.17 Аудитын явцад иргэдээс цахимаар авсан санал асуулгад 790 иргэн оролцож “Та төрийн байгууллагуудын үйлчилгээнд сэтгэл ханамжтай байдаг уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын **50.5 хувь** нь “Тийм”, **49.5 хувь** нь “Үгүй” гэсэн хариулт өгсөн байна.

2.3.18 Энэ нь төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжсэнээр төрийн үйлчилгээ авах шат дамжлага, иргэдийн цаг хугацаа хэмнэгдэж байгаа нь сэтгэл ханамжид эергээр нөлөөлсөн ч цаашид төрийн үйлчилгээг бүрэн цахим хэлбэрт шилжүүлж шат дамжлага, хүнд суртлыг бууруулах зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Сэлэнгэ аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг тусгайлан боловсруулж, мөрдөөгүй боловч аймгийн ИТХ-ын тогтоолоор “Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал”, “Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа” аймгийн хөтөлбөрүүдийг баталж, хэрэгжилтийг үнэлж, дүгнэсэн байна.
2. Төрийн албаны хүний нөөцийн хомсдол үүссэнээс төрийн албан хаагчдаар ажил хавсран гүйцэтгүүлэх, зэрэгцээ хөдөлмөр эрхлүүлэх, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдийг “Хөдөлмөрийн гэрээ”-гээр ажиллуулах явдал нийтлэг байдлаар оршиж байна.
3. Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах албан тушаал буюу төсвийн шууд захирагчийн сул ажлын байрыг нээлттэй зарлалгүйгээр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон иргэдийг эргүүлэн томилсон байна.
4. Төрийн байгууллагуудын удирдах албан тушаал буюу төсвийн шууд захирагчдыг түр орлон гүйцэтгэгчээр 2 жил гаруй хугацаанд гүйцэтгүүлж байна.

³⁰ Засгийн газрын Хэрэг эрхлэх газар жил бүр төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар хэрэглэгчийн үнэлгээ буюу судалгааг бүх аймаг, нийслэлийг хамруулан хийх ажлыг зохион байгуулна, Хэрэглэгчийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын баталсан ерөнхий удирдамжийг баримтлан хөндлөнгийн байгууллагыг судалгааны болон хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагын дундаас ажлын туршлага, хүний нөөцийн хүчин чадал зэргийг харгалзан сонгон шалгаруулна.

5. Сумдын ЭМТ-ийн дарга болон багийн Засаг дарга нарыг холбогдох хууль, журмын дагуу дагуу томилоогүй байна.
6. Зарим байгууллагууд сул ажлын байрыг хавсран гүйцэтгүүлж байгаа, албан тушаалын тодорхойлолт батлагдаагүй гэх үндэслэлээр сул ажлын байрны захиалгыг хүргүүлээгүй, нийтэд зарлан мэдээлээгүй байна.
7. ХНУМТ цахим системд албан хаагчдын хувь хүний мэдээлэл, ур чадвар, боловсрол, ажил эрхлэлтийн мэдээллүүдийг дутуу болон огт оруулаагүйгээс төрийн албан хаагчийн талаарх мэдээллийг бүрэн авах боломжгүй байна.
8. Төрийн албан хаагчдыг цахим болон танхимын сургалтуудад тогтмол хамруулж байгаа боловч үр дүнг тооцохгүй байна.
9. Сэлэнгэ аймаг нь 73 төрийн үйлчилгээг E-Mongolia системд холбож, операторын хэлбэрээр 64646 иргэнд үйлчилсэн байна.
10. Албан бичиг, мэдээлэл солилцооны цахим системүүдэд төрийн байгууллагуудыг бүрэн холбоогүй байна.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Аудитын түүврээр нийт **845,468.1** мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгуулах албан шаардлага бичигдлээ. Үүнд:

1. Өндөр насны тэтгэвэр тогтоолгож, төрийн албанаас чөлөөлөгдсөн иргэдийг төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сул ажлын байранд эргүүлэн томилж, 2023-2024 онд төсвөөс нийт **150,618.4** мянган төгрөгийн цалин олгосон байна. Үүнд:
 - Мандал сумын Тарни сургууль-цэцэрлэгийн цогцолборын дарга Д.Зэмбээ,
 - Аймгийн нэгдсэн музейн дарга М.Баярбаатар,
 - Мандал сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Ж.Бүрэнбуян,
 - Мандал сумын 2 дугаар сургуулийн захирал П.Сэлэнгэ,
 - Сэлэнгийн долгио чуулгын дарга Д.Уранбилэг,
2. Багийн ИНХ-аас нэр дэвшүүлээгүй иргэдийг багийн Засаг даргаар түр болон шууд томилж 2023 онд **177,954.2** мянган төгрөгийн цалин олгосон,
3. Сумдын ЭМТ-ийн даргын сул ажлын байранд сонгон шалгаруулалтгүйгээр шууд томилж, 2023 онд **254,702.7** мянган төгрөгийн цалин олгосон,
4. Төрийн албаны тусгай шалгалт өгөөгүй иргэдийг төрийн албанд түр томилж, 2023-2024 онуудад **262,192.8** мянган төгрөгийн цалин олгосон.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга Н.Лхагвадоржид:

1. Аймгийн хүний нөөцийн бодлогын төлөвлөлт, хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангах замаар аймгийн хэмжээнд мэргэжилтэй хүний нөөцийг бэлтгэх, тогтвортой ажиллуулах, сургаж хөгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх.

2. Холбогдох байгууллага, албан тушаалтнуудад хүсэлт гаргах замаар түр орлон гүйцэтгэгчээр 2 жил гаруй хугацаанд гүйцэтгүүлж буй удирдах албан тушаалтан буюу төсвийн шууд захирагчдын сонгон шалгаруулалтыг нэн даруй явуулж, жинхлэн томилуулах арга хэмжээ авах.
3. Албан бичиг, мэдээлэл солилцооны цахим системүүдэд төрийн байгууллагуудыг бүрэн холбох замаар өөр хоорондын уялдаа холбоог сайжруулах, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх.

Аймгийн ЗДТГ-ын дарга бөгөөд ТАЗ-ийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн дарга Ө.Сувдаад:

1. Албан тушаалын тодорхойлолтыг хянаж батлуулах, өөрчлөлт оруулахаар хүргүүлсэн байгууллагуудын хүсэлтийг шийдвэрлүүлэх замаар сул ажлын байрыг зарлан, нөхөх арга хэмжээ авах.
2. Харьяа байгууллагуудын хүний нөөцийн бүрдүүлэлт, сул ажлын байрны нөхөн томилгоо зэрэгт хяналт, шалгалт хийх замаар оршиж буй зөрчлийг арилгуулах.
3. Холбогдох байгууллага, албан тушаалтанд сургалт сурталчилгаа хийх, арга зүйн зөвлөгөө өгөх замаар ХНУМТ цахим системд оруулбал зохих мэдээллийг бүрэн оруулах арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангуулах.
4. Төрийн байгууллагууд хүний нөөцийн дутагдалтай байгаад үнэлэлт, дүгнэлт өгөх, шалтгаан нөхцөлийг тодорхойлох замаар төрийн албан тушаалыг хавсран гүйцэтгүүлэх, зэрэгцээ хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулах зэрэг зөрчлийг арилгуулах нөхцөл боломжийг судлан, холбогдох байгууллагуудад уламжлан, шийдвэрлүүлэх арга хэмжээ авах.

Төсвийн шууд захирагч нарт:

1. Төрийн албан хаагчдын сургалт хөгжлийн эрэлт хэрэгцээг тодорхойлж, хийгдэж буй сургалтуудын чанар, үр нөлөөг тооцох замаар хүний нөөцийн ур чадвар, чадавхыг нэмэгдүүлэх, үр дүнг үнэлэх.
2. Сул ажлын байрыг нөхөх захиалгыг ТАЗ-ийн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлд хүргүүлж, шийдвэрлүүлэх замаар төрийн байгууллагуудын албан тушаалтнуудыг томилох.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.БАТМӨНХ

АУДИТОР

О.АНХБАЯР

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛӨӨС
ИРҮҮЛСЭН САНАЛ



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛ

213200 Сүхбаатар, Сэлэнгэ аймаг,
Утас: 7036-3834

2024. 11. 20 № 109
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ч.ЭНХТУЯА ТАНАА

“Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого,
тогтолцооны үр нөлөө”-нд хийсэн гүйцэтгэлийн
аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Санал
байхгүй болно.

ДАРГА



Ө.СУВДАА

C:user:/albanbichig2024/TAZ A5

430303195